

## **ЧИГЛЭЛ ХҮРГҮҮЛЭВ**

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах чиглэлийг Хяналт шалгалтын газраас 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 8/10243 дугаар албан бичгээр аймаг, нийслэл дэх Улсын бүртгэлийн газар, хэлтсүүдэд хүргүүлэв.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Улсын бүртгэлийн болон холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд тооцохгүй бөгөөд 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө үйлдэгдсэн зөрчилд зохих хугацааг тооцон зөрчлийн хэргийг улсын бүртгэлийн нэгж дэх хяналтын улсын байцаагч хянан шийдвэрлэж байх талаар энэхүү чиглэлд дурдсан болно.

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**